



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ДОА-2021/19/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
Чойбалсан хот	бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
2021 он	Утас: 7058-4203
	Аудитын менежер: И.Сэмжидмаа
	Утас: 7058-4207
	Аудитор: Э.Нандинчимэг
	Утас: 7000-3775
	Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
	Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
	Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ЗТХС	Зам тээвэр хөгжлийн сайд
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3.Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	9
3.4. Материаллаг байдал	9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	10
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.9. Аудитын илрүүлэлт.....	11
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	11
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	12
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	13



1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 294

танай _____-ны № _____-т

Г ДОРНОД АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Д.ГАНЧИМЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Булган сумын соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Булган сумын соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Булган сумын соёлын төвийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 96 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020270



Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,945,420.00	17,119,942.40
35	БАРАА МАТЕРИАЛ	12,945,420.00	17,119,942.40
354	Хангамжийн материал	12,945,420.00	17,119,942.40
35420	Аж ахуйн материал	11,474,420.00	11,063,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,471,000.00	6,056,942.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	91,138,480.24	129,495,450.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	91,138,480.24	129,495,450.47
392	Биет хөрөнгө	88,138,480.24	126,495,450.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	68,556,019.54	68,556,019.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	(4,570,401.36)	(6,855,602.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,728,179.00	71,586,646.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,385,479.32)	(44,128,379.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,854,701.20	21,696,701.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,774,837.74)	(13,071,660.46)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,235,000.00	29,035,607.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,621,000.08)	(6,812,000.16)
39217	Ном	6,116,299.00	6,488,119.00
393	Биет бус хөрөнгө	3,000,000.00	3,000,000.00
39301	Програм хангамж	282,000.00	282,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(282,000.00)	(282,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,000,000.00	3,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	104,083,900.24	146,615,392.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	104,083,900.24	146,615,392.87
51	Засгийн газрын хувь оролцоо	104,083,900.24	146,615,392.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	110,930,574.20	110,930,574.20
51101	Өмч: - төрийн	110,930,574.20	110,930,574.20
512	Хуримтлагдсан үр дүн	(31,862,174.34)	10,669,318.29
51210	Өмнөх үеийн үр дүн	(31,862,174.34)	(31,862,174.34)
51220	Тайлант үеийн үр дүн	-	42,531,492.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,015,500.38	25,015,500.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	104,083,900.24	146,615,392.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	66,323,600.00	129,449,136.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	931,400.00	49,163,036.62
120	Нийтлэг татварын бус орлого	931,400.00	49,163,036.62
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	931,400.00	49,163,036.62
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	931,400.00	49,163,036.62
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		44,659,594.22
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		4,503,442.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,392,200.00	80,286,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	896,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	896,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	64,496,200.00	80,286,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,496,200.00	80,286,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	72,595,875.57	86,917,643.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,595,875.57	86,917,643.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,432,642.50	83,240,990.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,938,206.55	58,983,552.00
210101	Үндсэн цалин	39,941,699.55	58,983,552.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,996,507.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,976,988.38	7,835,349.00
210201	Тэтгэврийн даатгал	4,059,388.38	5,386,949.00
210202	Тэтгэмжийн даатгал	383,500.00	490,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	479,400.00	612,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	95,900.00	122,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	958,800.00	1,224,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,857,822.00	5,499,226.00
210301	Гэрэл, цахилгаан	861,894.00	441,186.00
210302	Тулш, халаалт	3,995,928.00	4,992,040.00
210303	Цэвэр, бохир ус	-	66,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,559,400.00	3,534,940.00
210401	Бичиг хэрэг	446,000.00	967,500.00
210402	Тээвэр, шатахуун	364,400.00	530,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	594,000.00	609,700.00
210404	Ном, хэвлэл	55,000.00	244,320.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100,000.00	880,000.00
210408	Бараа материал актисны зардал	-	302,900.00
2105	Нормативт зардал	800,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	995,950.00	-
210604	Урсгал засвар	995,950.00	-
2107	Томилголт, зочны зардал	-	482,000.00
210702	Дотоод албан томилолт	-	482,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,634,600.00	390,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,474,600.00	150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,669,675.57	6,515,923.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,663,675.57	6,515,923.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	163,233.07	3,676,653.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	163,233.07	3,676,653.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	163,233.07	3,676,653.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(6,272,275.57)	42,531,492.63
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,288,198.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,288,198.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,288,198.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(7,560,473.57)	42,531,492.63



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	65,392,200.00	80,286,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,392,200.00	80,286,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	896,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	896,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	64,496,200.00	80,286,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,496,200.00	80,286,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	65,392,200.00	80,286,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,392,200.00	80,286,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,228,966.93	76,609,447.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,938,206.55	58,983,552.00
210101	Үндсэн цалин	39,941,699.55	58,983,552.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,996,507.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,976,988.38	7,835,349.00
210201	Тэтгэврийн даатгал	4,059,388.38	5,386,949.00
210202	Тэтгэмжийн даатгал	383,500.00	490,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	479,400.00	612,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	95,900.00	122,300.00
210205	Эрүүд мэндийн даатгал	958,800.00	1,224,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,857,822.00	5,499,226.00
210301	Гэрэл, пахилгаан	861,894.00	441,186.00
210302	Түлш, халаалт	3,995,928.00	4,992,040.00
210303	Цэвэр, бохир ус	-	66,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,604,400.00	3,419,320.00
210401	Бичиг хэрэг	407,200.00	1,100,000.00
210402	Тээвэр, шатахуун	403,200.00	530,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	594,000.00	609,700.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	299,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100,000.00	880,000.00
2105	Нормативт зардал	800,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	995,950.00	-
210604	Урсгал засвар	995,950.00	-
2107	Томилголт, зочны зардал	-	482,000.00
210702	Дотоод албан томилголт	-	482,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,159,600.00	390,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,999,600.00	150,000.00
210802	Аудит, багагаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	896,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	896,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	163,233.07	3,676,653.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	163,233.07	3,676,653.00
213403	Төвлөрүүдэх шилжүүлэг	163,233.07	3,676,653.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)-(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	110,930,574.20	25,015,500.38	(31,862,174.34)	-	104,083,900.24
C02	Нягтлан бодох бүртгэлийн боллогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин нлэрхийлсэн үлдэгдэл	110,930,574.20	25,015,500.38	(31,862,174.34)	-	104,083,900.24
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	110,930,574.20	25,015,500.38	(31,862,174.34)	-	104,083,900.24
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	110,930,574.20	25,015,500.38	(31,862,174.34)	-	104,083,900.24
D02	Нягтлан бодох бүртгэлийн боллогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин нлэрхийлсэн үлдэгдэл	110,930,574.20	25,015,500.38	(31,862,174.34)	-	104,083,900.24
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	42,531,492.63	-	42,531,492.63
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	110,930,574.20	25,015,500.38	10,669,318.29	-	146,615,392.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,496,200.0	64,332,966.9	81,702,600.0	76,609,447.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,496,200.0	64,332,966.9	81,702,600.0	76,609,447.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,496,200.0	64,332,966.9	81,702,600.0	76,609,447.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,941,700.0	47,938,206.6	61,207,900.0	58,983,552.0
210101	Үндсэн цалин	39,941,700.0	39,941,699.6	61,207,900.0	58,983,552.0
210102	Нэмэгдэл	8,000,000.0	7,996,507.0	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,992,700.0	5,976,988.4	8,262,900.0	7,835,349.0
210201	Тэтгэрийн даатгал	4,075,100.0	4,059,388.4	5,814,700.0	5,386,949.0
210202	Тэтгэмжийн даатгал	383,500.0	383,500.0	490,000.0	490,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	479,400.0	479,400.0	612,100.0	612,100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	95,900.0	95,900.0	122,100.0	122,300.0
210205	Эрүүл мэндийн даатгал	958,800.0	958,800.0	1,224,000.0	1,224,000.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,997,400.0	4,857,822.0	5,989,200.0	5,499,226.0
210301	Гэрэл, цахилгаан	1,000,000.0	861,894.0	900,000.0	441,186.0
210302	Түлш, халаалт	3,997,400.0	3,995,928.0	5,023,200.0	4,992,040.0
210303	Цэвэр, бохир ус	-	-	66,000.0	66,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,604,400.0	1,604,400.0	3,882,600.0	3,419,320.0
210401	Бичиг хэрэг	407,200.0	407,200.0	1,310,900.0	1,100,000.0
210402	Тээвэр, шатахуун	403,200.0	403,200.0	781,800.0	530,520.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	594,000.0	594,000.0	609,900.0	609,700.0
210404	Ном, хэвлэл	100,000.0	100,000.0	300,000.0	299,100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100,000.0	100,000.0	880,000.0	880,000.0
2105	Нормативт зардал	800,000.0	800,000.0	1,215,000.0	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.0	800,000.0	1,215,000.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.0	995,950.0	-	-
210604	Урсгал засвар	1,000,000.0	995,950.0	-	-
2107	Төмшлөлт, зочны зардал	-	-	600,000.0	482,000.0
210702	Дотоод албан төмшлөлт	-	-	600,000.0	482,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,160,000.0	2,159,600.0	545,000.0	390,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.0	1,999,600.0	300,000.0	150,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.0	160,000.0	240,000.0	240,000.0
210807	Газрын төлбөр	-	-	5,000.0	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	64,496,200.0	64,332,966.9	81,702,600.0	76,609,447.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	64,496,200.0	64,332,966.9	81,702,600.0	76,609,447.0
132001	Орон нутгийн төсвөөс	64,496,200.0	64,332,966.9	81,702,600.0	76,609,447.0



3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Булган сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Ганчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25–ний хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Булган сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Булган сумын Соёлын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Өв соёлоо өвлүүлэн уламжлуулах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилго тавин ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган сумын Соёлын төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Булган сумын Соёлын төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.



Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 86,917.6 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 1,738.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган сумын Соёлын төв 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42,531.4 мянган төгрөгөөр буюу 41.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	12,945.4	17,119.9	4,174.5
Үндсэн хөрөнгө	152,490.2	197,363.0	44,872.8
Хуримтлагдсан элэгдэл	(64,351.7)	(70,867.6)	(6,515.9)
Нийт хөрөнгө	104,083.9	146,615.3	42,531.4
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	104,083.9	146,615.4	42,531.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	104,083.9	146,615.4	42,531.4

Бараа материалын дансны үлдэгдэл 17,119.9 мянган төгрөг болж 4,174.5 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар хөгжмийн хэрэгслүүд хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 197,363.0 мянган төгрөг болж 44,872.8 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯамнаас хөгжмийн зэмсэг, дагалдах хэрэгслүүд, тавилга эд хогшлыг хандивласнаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 146,615.4 мянган төгрөг болж 42,531.4 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

Булган сумын Соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 13,962.5 мянган төгрөгөөр буюу 21.1 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 10,808.3 мянган төгрөгөөр буюу 14.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагдсан зэргээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 81,702.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 81,702.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 81,702.6 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.



Тайлант онд гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 80,286.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 76,309.5 мянган төгрөгийг зарцуулж, 3,676.6 мянган төгрөг төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 66,818.9 мянган төгрөг буюу 87.6 хувийг эзэлж байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлтээр орлого ороогүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 143, хугацаа хоцроож мэдээлсэн 3 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитын зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,179.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12,179.9 мянган төгрөгийн зөрчилд 213.2 мянган төгрөгийн 2 акт тогтоож, 11,966.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 12,179.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 213.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 11,966.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 177.2 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтын хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

2. Томилолтын зардалд 36.0 мянган төгрөгийг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв



3. Тайлант оны эцэст үндсэн хөрөнгийн тооллого нь дэлгэрэнгүй бүртгэл дэх дүнгээс 11,318.7 мянган төгрөгийн дутуу, номын бүртгэл үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл дээр байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 12.2.2-т “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед”, УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант хугацаанд гарсан зардлаас 278.0 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

5. Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлд урсгал зардал гэсэн нэртэй 370.0 мянган төгрөг оны эхэн болон эцэст үлдэгдэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “...нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална” гэсэн заалт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөрөнгийн тооллогыг чанартай бодитоор хийхгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.



4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Дорнод аймгийн Булган сумын соёлын төв 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2021.02.25			ДОА-2021190/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:	Дорнод аймгийн Булган сумын Соёлын төв	Мянган төгрөг
------------------------------	---	---------------

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нийт 143 мэдээллийг оруулсан ба Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр 10,11 сар) 2 мэдээллийг хугацаа хоцроож, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр) 1 мэдээллийг байршуулаагүй байна.	-	Албан шаардлага өгөх	СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч	Д.Ганчимэг Х.Үржинлхам
2	Санхүүгийн тайланг бэлтгэхдээ хөрөнгийн тооллогыг тайлангийн дүнтэй тулгаагүй байна. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээрх дүн балансын хөрөнгийн дүнгээс 11318.7 мянган төгрөгийн зөрүүтэй. Номын бүртгэл хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл дээр байхгүй. Шинээр орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг НӨТ -гүй дүнгээр бүртгэснээс дээрх зөрүү үүссэн.	11,318.7	Албан шаардлага өгөх	СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч	Д.Ганчимэг Х.Үржинлхам
3	Бараа материал дээр урсгал засвар гэсэн материалын нэр дээр 370.0 мянган төгрөг эхэнд болон эцэст үлдэгдэлтэй.	370.0	Албан шаардлага өгөх	СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч	Д.Ганчимэг Х.Үржинлхам
4	Э.Гантулга, Ч.ГАНбаатар, Д.Ганчимэг нарын томилолтын зардал 482000 төгрөгийг бараа материалаар орлогодож зарлагдсан. Мөн Э.Гантулгын томилолтыг 2 өдрийн семинар хийх албан бичгээр 1 өдрийн баталсан хөтөлбөртэй 3 хоногийн томилолтын мөнгө олгосон буюу 1 өдөр илүү 36000 төгрөгийг буцаан тушаалгах. Д.Ганчимэгийн 09 сарын 28	36.0	Төлбөрийн акт тогтоох	СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч	Д.Ганчимэг Х.Үржинлхам



	-аас 10 сарын 03-ы 5 хоногийн томилолтоор явах тушаал байхгүй.				
5	МОНГОЛ ШУУДАН руу харилцахаас 408,5 мянган төгрөг шилжүүлсэн боловч цахим төлбөрийн систем 194,4 мянган төгрөг, МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО руу харилцахаас 609.7 мянган төгрөг шилжүүлсэн боловч цахим төлбөрийн системд 545.8 мянган төгрөгийг шивж, зэрүү 278.0 мянган төгрөгийг дутуу шивж илгээсэн байна.	278.0	Албан шаардлага өгөх	СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч	Д.Ганчимэг Х.Үржинлхам
6	Батлагдсан төсөв 166.5 мянган төгрөг, Зарцуулалт хэтрээгүй ч, жишиг нормоор тооцоолоход 45,2 мянган төгрөгийн илүү зарцуулалттай.	177.2	Төлбөрийн акт тогтоох	СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч	Д.Ганчимэг Х.Үржинлхам
ДҮН		12,179.9			